

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2024 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

2024 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРОО

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА

2024 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2 - 3
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	4 - 17

1. Байнгын хорооны тогтоолын төсөл /Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүний албан тушаалд нэр дэвшигчийн томилгооны сонсголын товыг тогтоох тухай/

4 - 17

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы
Хууль зүйн байнгын хорооны 11 дүгээр сарын 19-ний өдөр
/Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 22 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 59.1 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 52 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

*Томилолттой: Б.Заяабал, С.Одонтуяа;
Эмнэлгийн чөлөөтэй: У.Отгонбаяр;
Тасалсан: Н.Алтанхуяг, Х.Баттулга, Л.Мөнхбаатар, Б.Энхбаяр.*

Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүний албан тушаалд нэр дэвшигчийн томилгооны сонсголын товыг тогтоох тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Б.Галсанбат нар байлцав.

“Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүний албан тушаалд нэр дэвшигчийн томилгооны сонсголын товыг тогтоох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Д.Ганбат нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин, Ж.Алдаржавхлан, Д.Ганбат, Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар нар үг хэлэв.

Д.Цогтбаатар: “Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүний албан тушаалд нэр дэвшигчийн томилгооны сонсголын товыг тогтоох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 6
Бүгд: 15
60.0 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 15 цаг 22 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 31 минут үргэлжилж, 22 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 68.2 хувийн ирцтэйгээр 15 цаг 23 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА

Д.ЦОГТБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ХЭЛТСИЙН
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр, Мягмар гараг
Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхим
14 цаг 52 минут

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Цогтбаатар: Байнгын хорооныхоо гишүүдийн энэ өдрийн амрыг эрэн мэндчилье.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул Хууль зүйн байнгын хорооны 2024 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье. /алх цохив/

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 8.7-д заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя.

Хуралдаанд ирсэн гишүүд Д.Цогтбаатар, Ж.Алдаржавхлан, Э.Бат-Амгалан, Х.Баасанжаргал, Б.Бат-Эрдэнэ, Д.Ганбат гишүүн, Н.Нарантуяа-Нара гишүүн, О.Номинчимэг гишүүн, Б.Пүрэвдорж гишүүн, П.Сайнзориг гишүүн, Ц.Сандаг-Очир гишүүн, Х.Тэмүүжин гишүүн, Да.Цогтбаатар гишүүн гэсэн ийм ирцтэйгээр 59.1 хувийн ирцтэйгээр ирц бүрдсэн байна. Ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Өнөөдөр нэг асуудал байгаа.

Байнгын хорооны тогтоолын төсөл. Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүний албан тушаалд нэр дэвшигчийн томилгооны сонсголын товыг тогтоох тухай гэсэн ийм асуудал байгаа.

Тэгэхээр хэлэлцэх асуудлаар саналтай гишүүн байна уу? Нэрсээ өгье. Алга байна. Хэлэлцэх асуудлыг баталлаа. Хэлэлцэх асуудалдаа оръё.

“Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүний албан тушаалд нэр дэвшигчийн томилгооны сонсголын товыг тогтоох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцүүлье.

Хууль зүйн байнгын хорооны 2024 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн 05 дугаар тогтоол талаар байгуулагдсан Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах ажлын хэсэг хууль журамд заасны дагуу ажиллаж ажлын хэсгийн шийдвэр, ажлын хэсгийн тайлан, нэр дэвшигчийн холбогдох баримт бичгийг ажлын хэсгээс 2024 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр Хууль зүйн байнгын хороонд ирүүлсэн.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах журмын 13.2-т Байнгын хороо энэ журмын 13.1-д заасны дагуу хүсэлт, тайланг байршуулснаас хойш ажлын 5 өдрийн дотор томилгооны сонсголын товыг тогтоож, нийтэд мэдээлнэ гэж заасны дагуу Томилгооны сонсголын тов тогтоох тухай Байнгын хорооны тогтоолын төслийг батлах ёстой.

Тогтоолын төслийг Та бүгдэд тараасан байгаа.

Тогтоолын төсөлтэй холбоотойгоор Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах ажлын хэсгийн мэдээллийг Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Цэндийн Ц.Сандаг-Очир гишүүн танилцуулна.

Ц.Сандаг-Очир гишүүний микрофоныг өгье.

Ц.Сандаг-Очир: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын 2021 оны 3 дугаар сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөж эхэлсэн.

Уг хуулийн 77 дугаар зүйлд заасны дагуу Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнийг Улсын Их Хурал нээлттэйгээр нэр дэвшүүлж сонгон шалгаруулсны үндсэн дээр томилгооны сонсгол хийж томилохоор заасан.

Хууль зүйн байнгын хороо 2024 оны 10 дугаар сарын 02-ны өдөр хуралдаж Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвшигчийг 2024 оны 10 дугаар сарын 02-ны өдрөөс 2024 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн хооронд бүртгэхээр тогтсон бөгөөд нэр дэвшигчээр С.Энхбаатар, М.Алтан-Очир нар материалаа ирүүлсэн.

Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын 77 дугаар зүйлийн 77.2-т ажлын хэсэг нь Улсын Их Хурал дахь олонх цөөнх Ерөнхийлөгч, Засгийн газар, Хүний эрхийн Үндэсний Комисс, Монголын хуульчдын холбоо, Монголын өмгөөлөгчдийн холбоо, Хууль зүйн сургалт, судалгааны байгууллага, Хууль зүйн их, дээд сургуулийн санал болгосон төлөөллөөс бүрдсэн 11 гишүүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд ажлын хэсгийг Улсын Их Хурлын даргын захирамжаар томилсон Улсын Их Хурлын гишүүн ахална гэж заасан.

Уг заалтын дагуу Хууль зүйн байнгын хорооны 2024 оны 10 дугаар сарын 22-ны 05 дугаар тогтоолоор Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир миний бие ахалж, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн ажлын албаны дэд дарга О.Бат-Эрдэнэ, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн Хүний эрх, эрх зүйн бодлогын зөвлөх Х.Номингэрэл, Ерөнхийлөгчийн Тамгын газрын Хуулийн бодлогын газрын дарга Ж.Мөнхболд,

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга Б.Батцэцэг, Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн С.Дондов, Монголын хуульчдын холбооны зөвлөлийн гишүүн Ц.Мөнхбат, Монголын өмгөөлөгчдийн холбооны удирдах зөвлөлийн гишүүн З.Сүхбаатар, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал Х.Эрдэм-Ундрах, Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуулийн захирал Б.Амарсанаа, Отгонтэнгэр Их сургуулийн ахлах багш С.Эрдэнэболор нарын бүрэлдэхүүнтэй байгуулсан.

Хууль зүйн байнгын хорооны 2021 оны 3 дугаар сарын 10-ны өдрийн 6 дугаар тогтоолоор баталсан Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах журмын дагуу сонгон шалгаруулалтын зарыг нийтэд мэдээлэх, нэр дэвших тухай хүсэлт, материал хүлээн авах, ажлын хэсэг байгуулах, нэр дэвшигчдээ бүртгэж нийтэд мэдээлэх, нэр дэвшигчийн баримт бичгийг parliament.mn цахим хуудсанд байршуулах, нэр дэвшигчийн талаар мэдээлэл цуглуулах, бүрдүүлэх, ажлын хэсгийн ярилцлага зохион байгуулах, нэр дэвшигчийг тодруулан Улсын Их Хуралд санал болгох гэсэн 8 үе шатын хүрээнд зохион байгуулж саналаа Та бүхэнд танилцуулж байна.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд 2 хүний нэр дэвшихээр хүсэлт материалаа ирүүлснийг сонгон шалгаруулалтад оролцууллаа.

Хууль зүйн байнгын хорооны 2021 оны 3 дугаар сарын 10-ны өдрийн 6 дугаар тогтоолоор баталсан Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах журмын 12.6-д энэ журмын 12.1-д заасан хуралдаанаас хойш ажлын 3 өдрийн дотор энэ журамд заасны дагуу олонхын санал авсан нэр дэвшигчийн талаарх Ажлын хэсгийн тайлан, холбогдох баримт бичгийг Байнгын хороонд хүргүүлнэ гэж заасны дагуу Хууль зүйн байнгын хороонд хүргүүлэх зохицуулалттай.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд ажлын хэсгийн гишүүдийн олонхын санал авсан нэр дэвшигчдийг танилцуулж байна.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвшигч

1.С.Энхбаатар санал хураалтад 9 гишүүн оролцоноос 8 санал.

2.Алтан-Очир 9 гишүүн оролцоноос 1 санал авсан.

Хууль зүйн байнгын хорооны 2021 оны 3 дугаар сарын 10-ны өдрийн 06 дугаар тогтоолоор баталсан Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах журмын 13.2-т Байнгын хороо энэ журмын 13.1-д заасны дагуу хүсэлт, тайланг байршуулснаас хойш ажлын 5 өдрийн дотор Томилгооны сонсголын товыг тогтоож нийтэд мэдээлнэ гэж заасны дагуу Байнгын хорооны өнөөдрийн хуралдаанаар нэр дэвшигч нартай хийх томилгооны сонсголын товыг тогтоох тухай Байнгын хорооны төслийг танилцуулж байна.

Хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Д.Цогтбаатар: Ингээд тогтоолын төсөл болон ажлын хэсгийн танилцуулгатай холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Нэрсээ өгнө үү.

Д.Ганбат гишүүнээр тасаллаа. П.Сайнзориг гишүүний микрофоныг өгье.

П.Сайнзориг: Ингээд томилгооны сонсгол хийгдэх нь ээ.

Тэгэхээр ерөнхийдөө олон нийтэд мэдээллийг өгч, тэдгээрээс нэр дэвшигчтэй холбоотой мэдээллүүдийг цуглуулах үйл ажиллагаа явагддаг. Үүнийг аль болох нээлттэй, ил тодоор, өргөн хүрээнд явуулах шаардлагатай байх. Энэ дээр ажлын хэсгийн ахлагч анхаарч ажиллаасай гэж үзэж байгаа юм.

Би микрофон авч байгаа нь яах вэ маргааш эрүү шүүлэлтэд тулгах, хүнтэй хүнлэг бус хэрцгий хандахаас ангид байх эрхийн хэрэгжилтийн сонсгол Хууль зүйн байнгын хорооноос зохион байгуулна.

10.00 цагаас байгаа. Гишүүд маань ерөнхийдөө 50 дээр нэмэх нь нэг нь ирж байж энэ сонсгол ирцтэй болно.

Тийм учраас сонсголд Хууль зүйн байнгын хорооны гишүүд болон эргээд энэ сонсголыг зохион байгуулъя гэсэн гишүүд маань идэвхтэй оролцоосой гэж хүсэж байгаа.

Хоёрдугаарт, Хүний эрхийн Үндэсний Комиссын дүгнэлт болон холбогдох бусад эрх бүхий байгууллагуудаас ирсэн мэдээллүүдийг Хууль зүйн байнгын хорооны зөвлөх Г.Золжаргал өнөөдөртөө бүгдийг нь цэгцлээд өгнө гэж байгаа.

Ер нь түрүүчээс нь өгчихсөн. Тийм ээ.

Дээрээс нь 50 гаруй иргэд энэ сонсголд оролцож тодорхой эрх ашиг хөндөгдсөн эрх, хөндөгдсөн эрхээ сэргээлгэх, эргээд энэ хууль тогтоомж болон бусад зүйлүүд дээр санал шүүмжээ хэлнэ гэсэн ийм байдалтай байгаа шүү гэдэг зүйлийг хэлье.

Тэгээд яг энэ Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүний сонгон шалгар шалгаруулалтын ажлыг цаг алдалгүй хиймээр байна.

Энэ бас одоо тус институцийн бие даасан хараат бус ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ.

Тэгээд энэ дээр иргэд олон нийтэд мэдээллийг сайн өгч нэр дэвшигчтэй холбоотой мэдээллүүдийг цуглуулж иргэдийн оролцоог хангах чиглэлд анхаарч ажиллаасай. Одоо хэвлэл мэдээллийн байгууллагуудтайгаа сайн нягт ажиллаарай л гэж одоо хэлье дээ. Баярлалаа.

Д.Цогтбаатар: Баярлалаа. Д.Ганбат гишүүний микрофоныг өгье.

Манай гишүүд нээрээ маргааш тэр сонсголдоо. Энэ чинь манай Байнгын хорооны зохион байгуулж байгаа шинэ 126 гишүүнтэй Их Хурал эмхлэн байгуулагдсанаас хойш хийгдэж байгаа хүний эрхийн асуудлаарх маш том арга хэмжээ зохион байгуулагдаж байна. Манайхан ухамсартайгаар идэвхтэй оролцоорой гэж хүсмээр байна.

Д.Ганбат гишүүний микрофоныг өгье.

Д.Ганбат: Энэ Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах ажлын хэсэг маань их л сайн ажилласан бололтой. Их л олон цаас байна л даа. Бичиг баримтууд.

Тэгээд энэ цаасаараа байх ёстой бичиг цаасууд нь бүгд л байх шиг байна.

Тэгээд хэд хэдэн зүйл тодруулъя.

Энэ Шүүхийн ерөнхий зөвлөлийн энэ шүүгч бус гишүүнийг ийм цөөхөн хүн сонгон шалгаруулалтад оролцож байна уу, эсвэл хангалттай хүсэгчид байхгүй байна уу? Энд манай ажлын хэсэг ямар дүгнэлт хийж байна?

Хоёрхон хүн ороод, тэгээд нэг нь 9, нэг нь нэг санал авсан юм уу даа.

Тэгээд үүнийг ингээд харахаар ерөөсөө энэ хүмүүс тэртээ тэргүй энэ шаардлагад нийцэхгүй гэж өөрсдийгөө бодоод байна уу? Эсвэл энэ цаанаасаа дэглэчихсэн, хэн сонгогдох нь ойлгомжтой ийм ёс төдий үйл ажиллагаа болж байна гэж ойлгоод байна уу?

Энэ дээр ямар дүгнэлт хийж байна? Ажлын хэсэг. Уг нь ядаж 5, 6 хүн ороод, тэгээд шигшиж бариад ингээд явахгүй бол Шүүхийн ерөнхий зөвлөл чинь маш чухал байгууллага л даа. Үндсэн хуулийн.

Тэгээд нөгөө шүүгч нарыг чинь сонгон шалгаруулдаг ийм газар.

Тэгээд энд чинь одоо ийм олон хүн өрсөлдөхгүй байна гэдэг чинь болвсон хүчин тийм хангалтгүй байна уу? Эсвэл бидний шалгаруулж байгаа асуудалд асуудал байна уу гэдэг талаар манай ажлын хэсэг юу гэж бодож байна?

Д.Цогтбаатар: Ажлын хэсгийн дарга Ц.Сандаг-Очир гишүүний микрофоныг өгье.

Ц.Сандаг-Очир: Д.Ганбат гишүүний асуултад хариулъя.

Хууль зүйн байнгын хорооны даргын Хууль зүйн байнгын хорооны тогтоолоор батлагдсан ажлын хэсэг ажилласан.

Ажлын хэсэг Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах энэ журмын дагуу ажилласан.

Эхлээд зараа тавьж байгаа. Олон нийтэд мэдээлж байна. Нэр дэвших тухай хүсэлт материалаа хүлээж авч байна. Ажлын хэсгийг байгуулж байна. Нэр дэвшигчдээ бүртгэж байна. Нийтэд мэдээлж байна.

Мөн нэр дэвшигчийн баримт материалыг parliament.mn цахим сайт дээр байршуулж байна.

Нэр дэвшигчийн талаарх мэдээллийг цуглуулах, бүрдүүлэх, ажлын хэсгийн ярилцлага хийх, нэр дэвшигчийг тодруулан Улсын Их Хуралд санал болгох гэсэн 8 үе шаттай ажлыг журмын дагуу хийж байгаа юм.

Харамсалтай нь таны хэлдгээр сонгон шалгаруулалтад хоёрхон нэр дэвших хүсэлтэй, сонирхолтой 2 хүн материалаа бүрдүүлж өгсөн байна.

Ер нь зүгээр ярилцлагын үед гэдэг юм уу, ажлын хэсгийн явцын дунд олон гишүүн орж ирэх.

Ер нь шүүгч болох, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн болох хүсэл сонирхолтой иргэд хүсэл сонирхол их буурсан юм шиг харагдаж байгаа.

Тэгээд ямар учир шалтгаан байгаа юм. Ер нь.

Зүгээр журмын боловсруулалтыг анзаарахад журмыг олон хүмүүс, олсон олон өрсөлдөгч нар орж ирнэ гэсэн маягтайгаар хийсэн юм билээ.

Гэтэл яг хоёрхон хүн ороод ирсэн тохиолдолд олон хүн орж ирэхээр бид ажлын хэсэг жишээ нь одоо 5 хүн орлоо гэхэд бид 3-ыг Хууль зүйн байнгын хороонд оруулж ирэх ёстой юм байна лээ. Авсан саналаар нь эрэмбэлж.

Хууль зүйн байнгын хороо ахиж томилгооны сонсгол хийж эрэмбэлж хамгийн өндөр санал авсныг ингэж явах ёстой юм байна лээ.

Гэтэл харамсалтай нь 2 хүн ороод ирсэн тохиолдолд яах вэ гэдэг асуудал бас их сонин.

Тийм учраас нууц санал хураалтаар ажлын хэсэг 9 гишүүнээс хамгийн өндөр санал авсан 8. С.Энхбаатарыг. Мөн нэг санал авсан журмын дагуу 2-оор орж ирсэн 1 хүнийг бас оруулж ирж байгаа.

Яагаад гэхээр энэ журам дээрээ эрэмбээс санал авсан, олонхын санал авсан 2 хүртэл хүнийг. Ингээд нийтдээ хамгийн олон санал авсантайгаа нийлээд 3 хүртэл хүнийг Хууль зүйн байнгын хороогоор оруулж ирэх журамтай юм байна лээ.

Тийм учраас өнөөдрийн Хууль зүйн байнгын хороонд өндөр санал авсан болоод 2 дахь нэр дэвшигчийг хамтад нь оруулж ирж байгаа. Авсан саналынх нь эрэмбээр.

Ер нь сонирхол их буурсан шинжтэй харагдаж байна. Журмаараа яг яалт ч үгүй бүх хууль журамд заасан хугацаанд зар мэдээллийг тавьсан, олон нийтэд тавьсан, цахим сайтад байршуулсан, бүртгэж авсан гээд бүх procedурын үе шатууд журамд заасан хугацаандаа явж ирсэн.

Д.Цогтбаатар: Тэгэх үү. Тодруулах уу? Д.Ганбат гишүүн тодруулъя. Д.Ганбат гишүүний микрофон.

Д.Ганбат: Ингэхээр ингээд бидний сонгон шалгаруулах комисс маань журмынхаа дагуу ажиллажээ.

Гэвч журамдаа байна уу, эсвэл энэ байгаа юманд итгэлгүй байна уу? Хүмүүс. Ийм байна.

Тэгээд журмынхаа шаардлагыг ч хангахгүй болчихоод байна шүү дээ. 3 хүртэл хүн орж ирнэ гэж байна.

Тэгэхээр бид маш сайн улсуудаас шалгаруулж сонгох ёстой. Бид нарт ерөөсөө сонголтгүй болчихоод байна л даа.

Тэгэхээр энэ чинь сонгон шалгаруулах комисс ажилласан гэж үзэхэд хэцүү байна.

Тэгэхээр энэ журам, дүрмээ нэг ахиж хараад, тэгээд үүнийг одоо ер нь хойшлуулбал яасан юм.

Тэгж болохгүй ч биш л дээ. Журмын шаардлага хангахгүй байна. Эсвэл бид нарт байна уу. Энэ комисст одоо итгэхгүй байна уу. Юундаа байна?

Д.Цогтбаатар: Ц.Сандаг-Очир гишүүний микрофоныг өгье.

Ц.Сандаг-Очир: Тэгээд Д.Ганбат гишүүний саналтай шалгуур хангахгүй биш л дээ.

2 нэр дэвшигч материалаа өгсөн. Орж ирсэн 2 нэр дэвшигчийн хувьд журамд заасан шалгуур шаардлагыг бүрэн дүүрэн хангаж байна гэдгийг илтгэгч гишүүн сонгогдож ажиллаад, мэргэжил, боловсрол, ажилласан жил, туршлага гээд бүх одоо шалгуур шаардлагуудыг хангасан байна гэдэг ийм дүгнэлтийг илтгэгч

гишүүд ажлын хэсгийн гишүүдэд танилцуулсан. Шалгуур шаардлага хангаж байгаагийн хувьд 2 хүн шалгуур шаардлагаа хангасан 2 хүн байна гэж ингэж гарч ирсэн.

Зүгээр тооны хувьд асуудал байна. Олон хүн орж ирэх болов уу гэсэн бодол горьдлоготой байсан.

Харамсалтай нь 2 хүн орж ирсэн. Гэхдээ 2 хүн орж ирсэн, цөөхөн хүн орж ирсэн учраас энэ сонгон шалгаруулалтыг хойшлуулъя гэдэг асуудал. Мэдэхгүй. Би сайн мэдэхгүй байна. Боломжгүй байх гэсэн.

Хийдгээрээ сонгон шалгаруулалтаараа.

Д.Цогтбаатар: Баярлалаа. Д.Ганбат гишүүн ээ.

Тэгэхдээ таны тавьж байгаа асуулт маш зөв. Одоо манай Байнгын хорооны бидний хийгээд байгаа гол юм чинь яг энэ байгаад байгаа байхгүй юу. Та бүгд маань.

Нээрээ манай Байнгын хорооны гишүүд маань энэ дээр. Би бас гишүүддээ талархал илэрхийлмээр байгаа юм.

Яг шүүхийн хууль дээр бид төсөв эд нар дээр нь ингэж нарийвчилж ажиллаад байсны чинь учир нь яг амьдрал дээр энэ байгаа байхгүй юу. Одоо шүүхийн сонгон шалгаруулалт шүүгчийн зарлана шүү дээ.

Ирж байгаа хүмүүс маш цөөхөн. Тэгэнгүүтээ шалгалт авахаар. Одоо энэ 2 чинь тэнцээд орж ирж байна шүү дээ. Тэнцэж байгаа хүн байхгүй.

Яг таны хэлж байгаагаар энэ шүүхийг анхаарахгүй ингээд хаяж явснаас юу болсон байна гэхээр шүүгч болъё гэдэг хүсэлтэй хүн байхгүй.

Тэгээд ажлын ачаалал нь аягүй ихтэй, нэр хүнд юу ч байхгүй. Одоо аягүй олон аймгийн шүүх дээр ийм хоосон орон зай.

Тэгээд энэ чинь өөр аймгаас сэлгэн ажиллуулаад байгаа ийм юмнууд байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ дээр үнэхээр бид тэр төсөв эд нар дээр нь анхаарч ажиллаад байсны чинь цаад учир шалтгаан нь ерөөсөө л энэ амьдрал дээр одоо гараад ирж байгаа нь энэ байхгүй юу. Хоёрхон хүн юу өгөөд.

Энэ дээр 2 хүн орж ирлээ гээд бид буцаах боломжгүй байгаа.

Яагаад гэвэл хуулийн. Энэ чинь өдөр хоногтой. Ямар сайндаа бид өнөөдөр хуралдаж байгаа чинь одоо үүнээс хойш 5 хоногийн дотор дараагийн алхам

хийгдээ, тэгээд тэрний дотор тэрний дараа 14 хоногийн дараа байна уу нөгөө сонсгол эд нараа зохион байгуулах хуультай хугацаатай болчхож байгаа байхгүй юу.

Тэгээд бид үүнийг өнөөдөр энэ байгаа дүрэм журмаа л Хууль зүйн байнгын хороо дагаад явахаас өөр аргагүй байгаа юм.

Ингээд асуулт асууж дууслаа.

Тогтоолын төсөл болон ажлын хэсгийн танилцуулгатай холбогдуулан үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү.

Д.Ганбат гишүүн, Ж.Алдаржавхлан гишүүн, Г.Тэмүүжин гишүүн.

Та нар маань нэрээ өгөөрэй. Тэгвэл би жоохон хүлээгээдэхье.

Ж.Алдаржавхлан гишүүнээр тасаллаа. Г.Тэмүүжин гишүүний микрофоныг өгье.

Х.Тэмүүжин: Мэдээж хэрэг журмаараа процесс цаашаа үргэлжлэх байх.

Гэхдээ томилгооны сонсгол явагдсаны дараа Хууль зүйн байнгын хорооны дээр санал хураалт дэмжих дэмжихгүйгээр явагдахад Хууль зүйн байнгын хороо бол Улсын Их Хурлын гишүүд дэмжихгүй гэдэг санал өгөөд дахиад процессыг эхлүүлэх боломж нь нээлттэй байгаа шүү дээ.

Тэгээд тэр үед би ер нь боломжийг дахиж ашиглах нь зөв байх л гэж харж байна.

Зүгээр сая Д.Ганбат гишүүний хэлсэн нэг ноцтой зүйл өөрөө ингээд бидний дунд бас нэг хандлагын хувьд яваад байна.

Одоо ингээд шүүх рүү шүүгч нарын орон тоо байгаа боловч шүүхэд ажиллах сонирхолтой хүмүүс бас яг ийм байдалтай байна. Аль болох ирэхгүй, хойшоо суусан, зугтсан.

Өөрсдөө итгэлтэй байна уу, итгэлгүй байна уу гэдэг асуудал ерөөсөө биш. Тэр хүмүүс юу ярьж байна гэхээр их төвөгтэй, зовлонтой, ер нь зүгээр мэргэжлийн ажлаа хийх боломжгүй болчихлоо гэдэг ийм болгоомжлолоос болоод.

Хэтэрхий их улс төрждөг, хэтэрхий их дээр, доороос нөлөөлөх гэж оролддог. Тэр хүмүүсийн заавар чиглэлээр ажиллахгүй бол ер нь ажлаа алдах битгий хэл амьдралаа алдах хэмжээний улс төрийн шуурга нөмөрч байна гэдэг ийм болгоомжлол яваад байна.

Тийм учраас Хууль зүйн байнгын хороо ер нь цаашид Улсын Их Хурал зоригтойгоор энэ улс төржсөн шүүх дэх нөлөөллийг зогсоолгох талаарх тийм арга хэмжээ авахгүй бол эрх мэдлийн тэнцэл ер нь алдагдаж эхэлж байна шүү.

Улс төрчид Засгийн газар гүйцэтгэх эрх мэдэл, зарим талаараа хууль тогтоох эрх мэдэл, зарим талаараа Үндэсний аюулгүй байдлын зөвлөл гэдэг гарчиг доор нөгөө 3 даргын эрх мэдэл чинь ер нь хараат бус бие даасан хуульд захирагдаж ажиллах шүүхийг сууриар нь жоохон ганхуулах тийшээ очиж байна.

Мэдээж хэрэг шүүх байгууллага дотор ёс зүйгүй, захиа даалгаварт өртдөг, хувийн ашиг сонирхолдоо хөтлөгддөг тийм цөөн бус шүүгч байгаа гэдгийг үгүйсгэхгүй. Гэхдээ тогтолцоогоо нурааж болохгүй. Жоомоо алахад байшингаа шатаав гэгчээр.

Тэгэхээр тэрний нэг чиг хандлага сая энэ дээр бас анзаарагдаж байна. Хоёрхон хүн ирсэн байна.

Зүгээр хуульчдын нүдээр харах юм бол Шүүхийн ерөнхий зөвлөлийн түвшинд одоо ажиллах мэргэжилтний хувьд хоёулаа сул харагдаж байна.

Хуулийн шаардлагыг хангасан байж магадгүй. Нэр хүнд, нийгмийн хүлээн зөвшөөрөл, салбар дахь нөлөө гээд үүнийг чинь нөгөө ард нь хийх ажилд шаардагдах чадвар байгаа шүү дээ. Тэр чиглэлээс нь харах юм бол хоёулаа ер нь сул харагдаж байна.

Тийм учраас Хууль зүйн байнгын хороо процессынхоо дагуу ажлаа хийнэ. Гэхдээ бас энэ чиглэлээр бас бодох ёстой юм байна шүү. Энэ нэр дэвшигч дээр ч бодох асуудал байна цаана нь ер нь шүүхийн тогтолцоогоо яаж бэхжүүлэх юм, хараат бус байдлыг нь яаж баталгаажуулах юм гэдэг талаар бас анзаарч мэргэжлийн Байнгын хорооны хувьд анхаарч ажиллах шаардлага харагдаж байна шүү гэж хэлмээр байна.

Д.Цогтбаатар: Ж.Алдаржавхлан гишүүний микрофоныг өгье.

Ж.Алдаржавхлан: Би сая юуг уншчихаад нэг зүйлийг л дотроо бодож сууж байна.

21 хоног зарласан юм байна шүү дээ. 21 хоног зарлаад Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнийг сонгоё гээд Монгол Улс даяар зарлахад 2 хүн орж ирээд өрсөлджээ.

Тэгээд тэрийг нь бид сонсголоор хэлэлцээд томилох юм байна. Бусад албан тушаалтнууд зөвхөн нэг хүний гарын үсгээр томилогдож байгаа шүү дээ. Гэтэл энэ бол бас ардчилсан шинэ дэвшилт үзэл юм гэж би бодож байгаа.

Тийм учраас ер нь Хууль зүйн байнгын хорооны дарга аа,

Ер нь энэ төрийн олон албан тушаалтнуудыг ингэж ийм сонсголоор сонгодог ийм чиглэл рүү явах ёстой юм байна гэж би бодож байгаа.

Хүчний олон байгууллагууд байгаа. Монголбанкны Ерөнхийлөгч байж болно. Олон нийтийн хараанд байдаг олон байгууллагын тэргүүнүүдийг яг ийм нээлттэй зар тавиад өөрсдөө орж ирээд, тэгээд эргээд хариуцлагаа хүлээдэг байх ийм жишиг рүү бид шилжихгүй бол нэг хүний гарын үсгээр томилогдчихоод тэр хүнд эргэж үйлчилдэг энэ системээс Монгол Улс одоо ангижрах цаг болчихсон гэж би бодож байгаа.

Тийм учраас та Хууль зүйн байнгын хорооны даргын хувьд бусад хуулиуд дээр өөрчлөлт хийж хүчний олон байгууллагын дарга нар, энэ төрийн санхүүгийн олон байгууллагын дарга нарыг ийм нээлттэй сонсголоос сонгодог жишиг рүү явах тийм саналыг оруулаач ээ гэж би бас та бүгдээс хүсэж байна.

Хэдүүлээ бас ийм зүйл хийх юм бол Монголын төрд маш том шинэчлэлийг авчирна шүү гэсэн бодолтой байна.

Д.Цогтбаатар: Манай Хууль зүйн байнгын хорооны ажилтнууд, ажлын аппарат үүнийг тэмдэглээд аваарай.

Тэгээд энэ дээр зайлшгүй судалгаа хийгээд ямар боломж байна.

Мэдээж байгууллага болгон дээр ийм байдлаар хийх боломжгүй байж магадгүй. Яагаад гэвэл энэ аягүй урт хугацаатай процесс учраас.

Гэхдээ ингэж хийх шаардлагатай тийм албан тушаалуудыг нээрээ тодруулаад үзье.

Тэгээд судлаад үзье гэж бодож байна. Д.Ганбат гишүүний микрофоныг өгье.

Д.Ганбат: Д.Цогтбаатар дарга их зөв юм ярьж байна. Тийм. Угаасаа ч зөв юм ярьдаг хүн л дээ.

Гишүүн түүний зөв бурууг хэн мэдэх вэ дээ. Тийм.

Бас энэ танхимд бас энэ асуудлыг ойлгож байгаа ийм хүмүүс байхад бас талархалтай байна.

Энэ чинь уг нь цаашаа ингээд явахаараа нөгөө энэ институцээс итгэл байгаа юм л даа. Шүүх, шүүгчид итгэх, Шүүхийн ерөнхий зөвлөлд итгэх энэ итгэл нь ямар түвшинд байх вэ, яах вэ ийх вэ гэдгээ эндээс л шийдэгдэж байгаа.

Энэ сонгон шалгаруулах комисс, манай Хууль зүйн байнгын хороо үнэн шударгаар шалгаруулж чадаж байна уу, үгүй юу гэдгийг олон нийт харж байгаа

болохоор энэ удаа бид буцаах нь зөв гэдгийг гишүүд хэлж байна. Мэдээж хэрэг энэ 2 хүн ахиад л ороод л ирнэ биз.

Тэгээд бас 3, 4 хүн ороод ирвэл харьцуулж яриад, ингэхээр хүмүүсийн итгэл сэргэнэ.

Ямар ч байсан тэнд хэн нэгэн хүн бүгдийг нь төлөвлөчихсөн, нэг хүн ганцхан хүний санал аваад, хоёрхон хүн ороод нэг нь яагаад. Нэг тендер шалгаруулдаг шиг л юм болж байна шүү дээ. Урьд нь ярьчихсан тийм зураг ингээд харагдаад байна л даа.

Тийм ч байж болно, үгүй ч байж болно. Гэхдээ энэний цаана чинь өөрөө шүүх, шүүгчид итгэх итгэл, тэр сонгон шалгаруулах байгууллага хариуцлагатай ажилладаг уу, үгүй юу гэдэг ийм зүйл байгаа.

Тэгэхээр энд одоо бид хөнгөн хуумгай хандаж болохгүй. Зүгээр байдаг юм байдгаараа байна. Энэ шаардлага заримыг нь хангаж, зарим нь хангахгүй байна гэсэн ийм юм яриад ингэж өнгөрөөж болохгүй гэсэн ийм бодол саналтай байгаа юм байна.

Тэгээд түрүүн хэллээ. Санал хураагаад бид заавал дэмжих ёстой. Албатай ч биш.

Тэгээд саналаа гаргадгаараа гаргаад тэрүүгээрээ тэгээд дараагийн шатаар нь ямар нэгэн байдлаар хэлэлцээд. Тийм шат байдаггүй юм бол бий болгоод явсан нь зөв байх гэж бодож байна.

Д.Цогтбаатар: Баярлалаа. Би бас товчхон үг хэлчихье гэж бодож байна.

Гишүүд сая энэ яриад байгаа бол яах аргагүй бид санаа зовох асуудал мөн л дөө. Яагаад гэвэл энэ чинь нөгөө шүүхдээ эргээд хяналт тавих, тэр дээрээ илүү хариуцлагажуулах, хараат бус уг нь механизм байхгүй юу.

Тэгэхээр энэ дээр бид онцгой хариуцлагатай хандах ёстой.

Харин Д.Ганбат гишүүн ээ, энд нэг асуудал байгаа. Одоо эд нарыг бид явдаг процессоороо яваад буцаачихна шүү дээ. Эд нар нэр дэвшиж болохгүй юм байна шүү дээ. Энэ 2 хүн чинь болохгүй дахиж нэр дэвшихгүй юм байна.

Ингэнгүүт дахиад аягүй бол хоёр орж ирэх үү, яах вэ. Нэг иймэрхүү асуудал гарч болзошгүй л юм байна.

Гэхдээ энэ гишүүдийн бүрэн эрхийн асуудал. Та нар өөрсдөө дотоод итгэл үнэмшлээрээ л дараа нь юу саналаа өгч шийдвэрээ гаргана шүү дээ. Энэ тэгэхдээ бид саналаа оруулаад нэгдсэн чуулганаар асуудал шийдэгдэнэ.

Энэ дээр нэг зүйл. Түрүүн Г.Тэмүүжин гишүүний хэлсэн юун дээр тэр ингэмээр байгаа юм. Миний хувьд одоо энэ түрүүний Их Хурал дээр би нэг сүүлийн 6 сард л Хууль зүйн байнгын хорооны дарга хийсэн. Тэр хугацаандаа шүүхийг ил тод болгоё. Зөвхөн үндэсний аюулгүй байдлын асуудалтай холбогдсон маш нууцтай асуудлаас бусад бүх асуудлыг нь нээлттэй болгоно.

Тэр одоо аль нэг газрын дарга, нэг дунд шатны албан тушаалтан байгууллагын нууц гэснээс болоод тэр шүүх хуралдаан тэр чигээрээ нууц болоод байдаг байсан. Одоо бол байхгүй болчихсон.

Ямар сайндаа сая төсөв дээр чинь тоног төхөөрөмжүүд орж ирж байгаа чинь үүнийгээ шууд лайв стрийм хийх гээд тэр тоног төхөөрөмжүүд чинь орж ирж байгаа шүү дээ.

Одоо шүүх тэгэхээр ерөөсөө л үнэхээр ил тод болно. Энэ нэг арга. Нөгөө талаас нь би энэ Хүний эрхийн дэд хорооны дарга С.Эрдэнэболд даргатай эртээд нэг уулзаж ярьж суусан. С.Одонтуяа гишүүнтэй бас өмнөх парламентын үед ярьж байсан.

Юу гэвэл энэ ер нь шүүхийг ямар нэгэн хараат бус байлгахын тулд бас нэг хатуу хатуу хариуцлагатай арга хэмжээнд авч баймаар байгаа юм.

Миний нэг бодож байгаа юм бол жишээлбэл улс төрийн хилс хэрэгт холбогдсон хүмүүс байх юм бол тэр шийдвэр гаргасан даргаас нь авхуулаад энэ дээр хөөн хэлэлцэх хугацаа байхгүйгээр бүр тэрэнд оролцсон хүмүүс нас барсан байсан ч. Яагаад гэвэл нас барсан хүмүүсийг цагаатгаад байгаа шүү дээ. Тэгвэл тийм хэрэг хийсэн хүнийг нас барсан байсан ч хэргийг нь сөхөж гаргаж ирж болдог.

Тэгээд тэнд оролцсон прокурор, шүүх бүгдийг нь гаргаж ирж ярьдаг. Яагаад гэвэл энэ чинь нэг хүний хэрэг биш. Энэ чинь бүлэг хэрэг байгаад байгаа байхгүй юу.

Иймэрхүү болох юм бол дараа нь энэ чинь хэзээ ч дуусахгүй архиваас материалаа сөхөгдөж гарч ирээд асуудал болох юм байна гэдгээ мэддэг болох юм бол хүмүүс ядаад нэг нэгэндээ шахаж тийм янз бүрийн нөлөөлөл үзүүлэх шаанс нь багасгана.

Тэгэхээр иймэрхүү юмнууд байгаад байгаа. Энэ дээр Г.Тэмүүжин гишүүн ээ, би бол нээлттэй. Яг ярьж байгаад энэ шүүхийг хараат бус болгох дээр хангалттай юм бас хийгдэхгүй байгаад байгаа үнэн. Тэн дээр нь хэдүүлээ ажиллах ёстой шүү.

Үг хэлж дууслаа. Гишүүд. /алх цохив/

Ингээд Томилгооны тов товын тухай Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Гэхдээ би энд зүгээр Та бүгдэд тогтоолын төслийг тараачихсан байгаа. Товыг 12 дугаар сарын 06 гэдгээр товлож байгаа шүү.

Тэгээд энэ тогтоолын төслийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулья.

60.0 хувиар санал дэмжигдлээ.

Ингээд өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хүрэлцэн ирсэн гишүүддээ талархал илэрхийлье.

Хуралдаан дууссаныг зарлаж байна.

Хуралдаан 31 минут үргэлжилж, 15 цаг 23 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД